



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/356

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын 104 дүгээр
сургуулийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 36,704,430.66 (гучин зургаан сая долоон зуун дөрвөн мянга дөрвөн зуун гучин төгрөг жаран зургаан мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 104 дүгээр сургууль (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 12 нэр төрлийн 11,385,523.33 (арван нэгэн сая гурван зуун наян таван мянга таван зуун хорин гурван төгрөг гучин гурван мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 23 нэр төрлийн 25,318,907.33 (хорин таван сая гурван зуун арван найман мянга есөн зуун долоон төгрөг гучин гурван мөнгө) төгрөгийн хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 70,000 (далан мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 21,000 (хорин нэгэн мянга) төгрөгийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Нийслэлийн ерөнхий боловсролын 104 дүгээр сургууль (Д.Энхжаргал)-д, орлого төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс (М.Мандах)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050000993



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/358 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн ерөнхий боловсролын 104 дүгээр сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жилий	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Эвдрэл гэмтэл	ӨХЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал нэг бүрийн үнэ	ЭБХХК-ын хурлын шийдвэр
1	Шкаф шар нарийн бичиг	15	ш	1	251,111.60	251,111.60	251,111.60	-	эвдэрсэн	Актлах	устгах	устгах
2	Компьютерийн ширээ	15	ш	5	99,000.00	495,000.00	495,000.00	-	эвдэрсэн	Актлах	устгах	устгах
3	Бичгийн шкаф	14	ш	10	219,780.00	2,197,800.00	2,197,800.00	-	эвдэрсэн	Актлах	устгах	устгах
4	Проекторын дэлгэц	12	м	1	313,338.00	313,338.00	313,338.00	-	эвдэрсэн	Актлах	устгах	устгах
5	Теннисний ширээ	11	ш	1	700,000.00	700,000.00	700,000.00	-	эвдэрсэн	Актлах	устгах	устгах
6	Төмөр шкаф	11	ш	3	250,000.00	750,000.00	750,000.00	-	эвдэрсэн	Актлах	устгах	устгах
7	Хөл бөмбөгийн хаалга	11	ш	1	380,000.00	380,000.00	380,000.00	-	эвдэрсэн	Актлах	3,000	3,000
8	Зурагтын тавиур	11	ш	1	125,000.00	125,000.00	125,000.00	-	эвдэрсэн	Актлах	устгах	устгах
9	Номын шүүгээ	11	ш	4	187,500.00	750,000.00	750,000.00	-	эвдэрсэн	Актлах	устгах	устгах
10	Шкаф	10	ш	4	360,000.00	1,440,000.00	1,440,000.00	-	эвдэрсэн	Актлах	4,000	4,000
	Тавилга эд хогшлын дүн			31		7,402,249.60	7,402,249.60	-			7,000	7,000
11	Сүлжээний радиотар	14	ш	1	93,766.14	93,766.14	93,766.14	-	эвдэрсэн	Актлах	1,000	1,000
12	Ямаха даралтат хөгжим	15	ш	1	913,885.94	913,885.94	913,885.94	-	эвдэрсэн	Актлах	устгах	устгах
13	HP лазер принтер	14	ш	1	415,017.90	415,017.90	415,017.90	-	эвдэрсэн	Актлах	2,000	2,000
14	НД дэвтрийн сейф	14	ш	1	61,050.00	61,050.00	61,050.00	-	эвдэрсэн	Актлах	1,000	1,000
15	Канон	13	ш	1	1,709,387.79	1,709,387.79	1,709,387.79	-	эвдэрсэн	Актлах	устгах	устгах
16	Өсгөгч /УИХ гишүүн/	13	ш	1	1,465,200.00	1,465,200.00	1,465,200.00	-	эвдэрсэн	Актлах	3,000	3,000
17	Проектор	13	ш	1	1,279,119.60	1,279,119.60	1,279,119.60	-	эвдэрсэн	Актлах	1,000	1,000
18	Шарах шүүгээ MWLG-6652i	13	ш	1	366,287.79	366,287.79	366,287.79	-	эвдэрсэн	Актлах	3,000	3,000
19	Зөөврийн компьютер toshiba /УИХ/	13	ш	1	1,953,600.00	1,953,600.00	1,953,600.00	-	эвдэрсэн	Актлах	1,000	1,000

